

МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БОДЛОГО

“Титан Си Ар Эй ЗМС” ХХК-ийн мэдээллийн аюулгүй байдлын бодлого нь мэдээлэл нийлүүлэгч, хэрэглэгч, харилцагчийн хууль ёсны эрх ашиг, сэтгэл ханамж, итгэлийг хадгалах зорилгоор өөрийн үйл ажиллагааны хүрээнд үүссэн, цуглуулсан, боловсруулсан бүх мэдээллийг үнэ цэнтэй хөрөнгө гэж үзэн бусдад зөвшөөрөлгүй задруулах, өөрчлөгдөх, устгахаас хамгаалах арга хэмжээг мэдээллийн аюулгүй байдлын олон улсын стандартуудад нийцүүлэн хэрэгжүүлж, тасралтгүй сайжруулахад оршино.

ЭНЭХҮҮ БОДЛОГЫГ ДАРААХ ЧИГЛЭЛЭЭР ХЭРЭГЖҮҮЛНЭ

Мэдээллийн хөрөнгийн нууцлалтай, бүрэн бүтэн, хүртээмжтэй байдлыг хангах

Мэдээллийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд ажилтан, хэрэглэгч, мэдээлэл нийлүүлэгч, гүйцэтгэгчдийн оролцоог хангах

Оролцогч талуудад мэдээллийн аюулгүй байдлыг хангах талаар мэдлэг олгож, чадавхжуулах

Мэдээллийн аюулгүй байдлыг тогтмол хянах, үнэлэх, сайжруулах арга хэмжээг тасралтгүй хэрэгжүүлэх

Монгол Улсын болон олон улсын хууль тогтоомж, стандартад нийцсэн үйл ажиллагаа явуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангасан орчин бүрдүүлэх

Мэдээллийн аюулгүй байдлын зөрчилд үр дүнтэй хариу арга хэмжээ авч, давтан гарахаас урьдчилан сэргийлэх